

Хилийн чанадад оршин суугаа иргэд үндэсний энгийн гадаад паспорт захиалах журамд нэмэлт өөр

Бичсэн stockholm

2017 оны 3-р сарын 16, Пүрэв гариг, 15:42 - Сvvлд шинэчлэгдсэн 2017 оны 3-р сарын 16, Пүрэв гариг, 15:45

There are no translations available.

Хилийн чанадад оршин суугаа иргэд Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспорт захиалах ажиллагааг шуурхай болгох асуудлын хүрээнд 2017 оны 1 дүгээр сарын 13-ны одор “Үндэсний энгийн гадаад паспорт олгох ажиллагааг хялбаршуулах тухай” Гадаад харилцааны яамны Торийн нарийн бичгийн дарга, Хууль зүй, дотоод хэргийн яамны Торийн нарийн бичгийн даргын хамтарсан а/07, а/02 тоот тушаал батлагдсантай холбогдуулан 2017 оны 3 дугаар сарын 14-ний одроос үндэсний энгийн гадаад паспортыг цахим хэлбэрээр захиалах журам руу шилжээд байна.

ЭСЯ хилийн чанадад оршин суугаа иргэдийн үндэсний энгийн гадаад паспортын захиалгыг хвлээн авч Оюуны Омч, Улсын Бvртгэлийн Ерөнхий Газар /цаашид ООУБЕГ гэх/-т хvргvвлж, хэвлэгдэн гарсан гадаад паспортыг буцаан авч, баталгаажуулан иргэдэд хвлээлгэн огох вйл ажиллагаа нь ихээхэн хугацаа шаарддаг байсан ба дээрх журам хэрэгжиж эхэлснээр паспорт захиалгын хугацааг тvргэсэх ондор ач холбогдолтой болоод байгаа юм.

Иргэд үндэсний энгийн гадаад паспорт захиалахад шаардагдах бичиг баримтыг бvрдvвлэхэд дараах нэмэлт оорчлолт орсон болно. Үвнд:

Иргэд тус ЭСЯ-ны цахим хуудас дахь үндэсний энгийн гадаад паспорт захиалахад шаардагдах бичиг баримтын жагсаалтад дурдагсан материалыг бvрдvвлэхээс гадна оорийн биеэр ЭСЯ-нд ирж цээж зурагаа авахуулах эсвэл оорийн биеэр ирэх боломжгvй, паспорт захиалгын материалаа шуудангаар илгээж буй иргэд 3,5 x 4,5 см хэмжээтэй **цээж зурагаа** цахим хэлбэрээр тус ЭСЯ-ны цахим шуудан болон фэйсбvвк хуудсаар дамжуулан ирvвлэх шаардлагатай болоод байна. Мон цээж зурагаа цахим хэлбэрээр ирvвлэхдээ паспорт захиалж буй хvний эцэг/эх-ийн нэр, нэр, регистрийн дугаарыг тодорхой тусгах хэрэгтэй.

Дээрх оорчлолтийн дvнд иргэдээс цахим хэлбэрээр ирvвлсэн цээж зургийг гадаад паспорт захиалж буй иргэний холбогдох мэдээллийн хамт цахим хэлбэрээр ООУБЕГ руу илгээснээр тус газарт хэвлэгдэж бэлэн болсон гадаад паспортыг ЭСЯ руу буцаан хvргvвлж ажиллахаар болсон ба паспорт захиалгын материалын эх хувийг ООУБЕГ-т хvргvвлэхийг хвлээх шаардлагагvй болсноороо давуу талтай юм.

Хилийн чанадад оршин суугаа иргэд үндэсний энгийн гадаад паспорт захиалах журамд нэмэлт өөр

Бичсэн stockholm

2017 оны 3-р сарын 16, Пүрэв гариг, 15:42 - Сүүлд шинэчлэгдсэн 2017 оны 3-р сарын 16, Пүрэв гариг, 15:45

Иймд иргэд та бүхэн үндэсний энгийн гадаад паспорт захиалахдаа тус ЭСЯ-нд цээж зурагаа авахуулах болон оорийн биер ирж чадахгүй тохиолдолд шаардлага хангасан цээж зурагаа тус ЭСЯ руу цахимаар хүргүүлэх шаардлагатай болохыг анхаарна уу.

Жич: Тус ЭСЯ-нд иргэдийн цээж зургийг хэвлэхгүй бөгөөд зөвхөн цахим хэлбэрээр хадгалж авах тул 3 ширхэг цээж зурагаа гадаад паспорт захиалгын материалдаа зайлшгүй хавсаргах шаардлагатайг анхаарна уу.

Дэлгэрэнгүй мэдээллийг [эндээс](#) харна уу.

Монгол Улсаас Шведийн Вант Улсад суугаа Элчин сайдын яам